

Амлалт (The promise)
C. Wright Mills

Амлалт гэдэг энэхүү эссэг АНУ-ын социологич С. Wright Mills 1959 онд бичсэн ба энэ нь орчин үеийн социологийн алдартай бүтээлүүдийн нэгд тооцогддог. Энэхүү эссэгээрээ Миллс хүмүүсийн зан үйлийг хэрхэн ойлгох, хувь хүмүүсийг авч үзэхдээ түүний амьдран буй нийгмийн нөхцөлтэй нь холбон авч үзэх зайлшгүй шаардлагатай болохыг өгүүлсэн юм. Хувь хүмүүс өдөр тутамдаа байнга ямар нэгэн сонголтыг хийж байдаг, гэхдээ тэрхүү сонголт нь нийгэм, түүх, соёл, улс төр, эдийн засгийн хүчин зүйлээс хамаарч байдаг билээ. Хүмүүсийн амьдрал нь тэдгээрийг хүрээлэн буй, тэдгээрээс ангид, тэдний хяналтаас гадуур оршин буй хүчин зүйлсийн нөлөөнд байдаг гэдгийг хүн бүр мэддэггүй. Хэрвээ бид хүмүүсийн зан үйлийн мөн чанарыг ойлгох аваас тэрхүү зан үйлийнх нь хувийн биш хүчин зүйлсийг тооцоолж чадна. Иймээс социологийн нийгмийг танин мэдэхүйн мөн чанарыг ойлгохын тулд энэхүү алдартай эссэг оюутан та бүхэнд орчуулан толилуулж байна.

Өнөө үед хүмүүс хувийн амьдрал нь сүлжилдсэн торон дотор өнгөрч байгааг мэддэг. Тэд өдөр тутмын амьдрал үйл ажиллагааны хүрээнд өөрсдөд учирсан саад бэрхшээл бүрээ даван туулж чадахгүй байгаа ч үргэлжид өөрсдийгөө зөвтгөдөг. Жирийн хувь хүн хувийн амьдралынхаа орчил хүрэн дотроо л ямар нэг юм хийхээр хичээж байдаг; тэдний тэмүүлэл болон эрх мэдэл нь тэдний ойр хүрээний орчны гэр бүл, ажил, амьдран суугаа орон нутагт болж буй үйл явдлаар хязгаарлагддаг; мөн нийгмийн өөр орчинд тухайн хүн хөндлөнгийн ажиглагч эсвэл орлон гүйцэтгэгч болон хувирдаг гэдгээ мэддэг. Хүний өөрийнх нь гол үйл ажиллагаанууд нь явагдаж байдаг орчны хүрээнээс түүний хүсэл зорилго, хүсэл зорилгоо биелүүлэхэд нь учирч буй саад бэрхшээл нь даван гарах үед тэд илүү том сүлжилдсэн торонд холбогдож байгаагаа мэдэрч ойлгодог.

Илүү том сүлжилдсэн торонд байгаагаа мэдрэх нь нийгмийн өргөн хүрээний бүтэц дэх хувийн биш өөрчлөлт гарч байгааг илтгэх юм. Орчин үеийн нийгмийн түүхийн баримтууд нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн амьдралын уналт хийгээд амжилтыг илтгэж байдаг. Нийгэм аж үйлдвэржих үед тариачин хүн ажилчин болж феодаль буюу газрын эзэн нь дампуурч эсвэл бизнесмэн болон хувирдаг. Ангийн ялгарал өсөх/буурах тохиолдолд хүн ажилтай болж эсвэл ажлаа алддаг, хөрөнгө оруулалтын түвшин нэмэгдэх/буурах үед хүн шинэ зүйлтэй болж эсвэл юу ч үгүй болж байдаг. Дайн болох үед даатгалын ажилтан пуужин хөөргөгч, дэргүүрийн худалдагч нь радиолокацийн ажилтан болж, эхнэрүүд ганцаар амьдарч, хүүхдүүд эцэггүйгээр өсөн торниход хүрдэг. Ийнхүү нэг хүний хувийн амьдралын түүх хийгээд нийгмийн түүхийг тус тусад нь салган авч үзэх боломжгүй юм.

Хүмүүс өнөө хэр өөрсдийнх нь амьдралд тулгарч буй саад бэрхшээлийг түүхэн өөрчлөлт, институтуудын зөрчлөөс хамааран даван туулдаг гэж хэзээ ч боддоггүй. Тэд өөрсдийн амьдран буй нийгмийн өсөлт, уруудалтад өөрсдийгөө хэзээ ч буруутгадаггүй. Хааяа нэг хувь хүн өөрийн хувийн амьдрал хийгээд нийгмийн түүх¹ хоорондын уялдаа холбоог мэддэг ч, жирийн хүн энэхүү холбоо нь тухайн хүнийг ямар хэв маягийн хүн болох, өөрөө нэгээхэн хэсэг нь болж буй нийгмийн түүхэн хэв маяг бүрэлдэхэд ямар утга ач холбогдолтой болохыг ойлгодоггүй. Хүмүүс хүн хийгээд нийгэм, хувийн намтар хийгээд түүх, хувь хүн ба дэлхий ертөнцийг хоорондоо нягт уялдаа холбоотой хэмээн үздэггүй. Тэд өөрсдөд нь тохиолдож буй бэрхшээлийг өөрөөс нь гадна орших нийгмийн бүтцийн шилжилтийн нөлөөг тооцоолох замаар даван туулж чаддаггүй.

Мэдээж, үүнд эргэлзэх шаардлагагүй. Ямар цаг үед хүмүүс нийгмийн эрс өөрчлөлтийн давалгаанд хөл нийлүүлэх шаардлагатай болж байсан бэ? Америкчууд бусад нийгмийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн туулсан шиг нийгмийн хатуу ширүүн өөрчлөлтийн түүхэн нөлөөг сайн мэдэхгүй. Хүн бүхний амьдралд нөлөөлж буй түүх бол нийгмийн түүх. Нэгэн үйл явдал, нэг цаг үе, хүн төрөлхтөний нэгэн үе, нэгэн жарныг авч үзвэл феодалийн харилцаа, илүү хоцрогдсон байдлаас

¹ Зохиогч world history хэмээн ихэвчлэн бичсэн хэдий ч уншигчид илүү ойлгомжтой байлгах үүднээс нийгмийн түүх хэмээн хөрвүүлээ.

орчин үеийн, илүү боловсронгуй хийгээд аюултай байдал руу шилжсэн шилжилт байдаг. Мөн колониолоос улс орнууд чөлөөлөгдөж, империализмын хэлбэр шинээр үл ажиглагдам байдлаар суурьшиж байна. Хувьсгал гарч, хүмүүс эрх мэдлийн өөр хэлбэрийг хүлээн авч байна. Тоталитари нийгмүүд бий болж, нуран унаж, эсвэл үнэмшиггүй байдлаар амжилтад хүрч байна. Капитализм ноёрхож эхэлсэн хоёр зуун жил өнгөрсөний дараагаар тэр нь нийгмийг аж үйлдвэржсэн аппарат бүхий болгон хувиргах нэг л арга зам болохыг харж байна. Ардчилалыг албан ёсоор хүлээн зөвшөөрснөөс хойш хоёр зуун өнгөрөөд байгаа ч, хүн төрөлхтөний тун бага хэсгийг л хамарч байна. Хөгжил дорой бүхий л орнуудад уламжлалт амьдралын хэв маяг нь эвдэгдэж, өмнө нь мэддэггүй байсан зүйл маш хурдан хэрэгтэй зүйл нь болж хувирч байна. Хөгжингүй улс орнуудад эрх мэдэл хийгээд хүч хэрэглэх явдал нь хязгаарлагдах болсон. Хүмүүнлэгийн үнэт зүйлс уналтад орж, зөрчилдөгч Супер Үндэстэн Дэлхийн 3-р дайнд бэлтгэхээр анхаарлаа хандуулж байна.

Хэлбэржсэн түүх нь эрхэмлэгдэн дээдлэгдэж буй үнэт зүйлсэд өөрийгөө тохируулан биеэ авч явах хүний чадвараас давах болжээ. Ямар үнэт зүйлс вэ? Хүмүүс уламжлалт мэдрэмж, сэтгэлгээ нь хуучирч байгааг байнга мэдэрч байдаг ба шинээр эхлүүлэгчид нь ёс суртахууны хувьд хуучныг баримталж байгаагаараа хоёрдмол шинжтэй болж байдаг. Жирийн хүн өөртэйгээ зэрэгцэн оршин байдаг томоохон ертөнцийг даван гарч чаддаггүй гэдгээ мэдэрдэг гэдэг нь эргэлзээтэй зүйл үү? Жирийн хүн өөрийн амьдран буй эрин үеийнхээ мөн чанарыг ойлгодоггүй гэсэн үг үү? Хувиа бодон, ёс суртахууныг умартан нэг мөсөн өөрийн хувийн өртөнцөө хамгаалан үлдэхээр хичээдэг гэсэн үг үү? Хувь хүн нийгэмд сүлжилдэн оршин байдаг тухай мэдэрдэг гэдэг нь эргэлзээтэй зүйл үү?

Хүмүүст хэрэгтэй байгаа зүйл нь мэдээлэл төдий зүйл биш. Мэдээлэл нь хүмүүсийн анхаарлыг татаж байдаг ч, тэдний хүлээн авах чадвараас нь даван гарсан байдаг. Мөн хүмүүст хэрэгтэй байгаа зүйл нь шалтгаалчлалын дүн шинжилгээ хийх чадвар төдий зүйл биш. Хэдийгээр уг чадварыг эзэмших гэсэн чармайлт нь үргэлжид хүмүүсийн хүчийг барж байдаг.

Хүмүүс өөрт нь юу хэрэгтэй байгаа, хэрэгтэй зүйлийнхээ юуг тэд өөрсдөө мэдэх явдал нь мэдээллийг хэрхэн ашиглах, нийгмийн ертөнц дээр юу, хэрхэн явагдаж байдагийг илүү тодорхой мэдэхийн тулд шалгаалчлалын дүн шинжилгээний ур чадварыг хөгжүүлэх, улмаар нийгэмд ямар зүйлс өөрөө аяндаа тохиолдож болохыг ойлгоход нь дэмжлэг үзүүлэх чанартай танин мэдэхүй юм. Би вээр сэтгүүлч, эрдэмтэн, жүжигчин, төрийн ажилтан, судлаач, редакторууд чухамхүү социологи бодит байдлыг хэрхэн дүрслэн харуулдаг вэ гэдэгт хариу хүлээж байгаа бөгөөд тэдний энэхүү асуултад өөрийнхөөрөө хариулт өгөхийг хүссэн юм.

Нэг.

Социологийн бодит байдлын дүрслэл нь түүнийг хийхээр зоригчдод янз бүрийн хувь хүмүүсийн хувийн хийгээд ажил хэргийн амьдралыг томоохон түүхэн цар хүрээнд авч үзэж тэрхүү түүхэн нөхцлийн хувь хүнд илрэх утга учрыг ойлгох боломжийг олгодог. Энэ нь хувь хүмүүс өөрсдийн өдөр тутмын эмх замбараагүйгээр өрнөж буй үйл ажиллагааны хүрээнд өөрсдийн нийгмийн байр суурийн алдаатай ухамсартай хэрхэн болж байгааг тооцоолоход тусална. Энэхүү өдөр тутмын эх замбараагүй амьдралын явцад орчин нийгмийн үндэс суурь нь аль хэдийн танил зүйл болсон бөгөөд энэхүү үндэс суурин дээр ялгаатай эрэгтэй, эмэгтэйчүүдийн сэтгэл зүй бүрэлдэн тогтдог. Энэ утгаараа хувь хүний түгшүүр нь хувь хүмүүст тулгарсан тодорхой бэрхшээлийн тусгал ба олон нийтэд тулгарсан нийтлэг асуудал нь тэднийг ижилсүүлдэг.

Социологийн дүрслэлийн хамгийн эхний үр ашиг бол хувь хүн өөрийн амьдралын туршлагаа хэрхэн ойлгох мөн өөрийн цаг үедээ өөрийн эзлэн буй байр суурийн боломжуудыг мэдэх замаар амьдралын хувь тавилангаа урьдчилан тооцоолж чадахад нь туслах юм. Олон талаараа энэ бол гайхалтай бөгөөд том амжилт. Бид хүний чадавхи нь дээд зэргийн амжилтад хүрэх эсвэл болзошгүй уналт гаргах, шаналгаа, баяр хөөр эсвэл уйтгар шаналал, хүсэл мөрөөдөл, амттай амьдралд хүрэх эсэхийг бүрэн тодорхойлж чаддаггүй хязгаарлагдмал гэдгийг бид мэддэггүй. Гэвч бид өнөө үед хүний чадавхийн хязгаарлагддаг байдал улам бүр томорч өргөжиж байгааг мэддэг болж байна. Бид зарим нийгэмд хувь хүн бүр нэг үеэс нөгөө үе рүү шилжин, тэр хүн өөрийн

намтраасаа гадуур мөн түүхэн нөхцөл байдлаас гадуур амьдардаг гэдгийг мэддэг болж байна. Түүний амьдарч байгаагийн баримт нь минут тус бүрт өөрийн хувь нэмрээ нийгэм, түүний түүхэнд оруулж байдаг ба түүхийг хөдөлгөж, түлхэж өгөх замаар өөрийн нийгмээ бүтээдэг.

Социологи нь бидэнд хувийн намтар хийгээд түүх, тэдгээрийн харилцаа холбоог ойлгох боломжийг олгодог. Эдгээр нь түүний үүрэг бөгөөд амлалт нь юм. Мөн энэ нь хүн хийгээд нийгмийн тухайн орчин үеийн судалгааны хамгийн шилдэг нь юу гэдгийг илэрхийлнэ.

Хувийн намтар хийгээд түүх, тэдгээрийн хоорондын уялдааны асуудлыг хөндсөн нийгмийн судалгааны танин мэдэхүйн аялал нь дуусахгүй мөн чанартай. Сонгодог нийгмийн шинжилгээний ямар ч асуудлууд нь хэдийгээр нийгмийн бодит байдлын хязгаарлагдмал эсвэл өргөн хүрээг хамарч байгаа ч шалгагдан үнэлэгддэг. Тэдний амласан ажил дараах гурван төрлийн асуултыг үргэлжид асууж байдаг юм. Үүнд:

1. Тухайн бүхэллэг нийгмийн бүтэц нь юу вэ? Ямар ямар амин чухал бүрэлдэхүүн хэсгээс тогтож байгаа вэ? Тэдгээр нь өөр хоорондоо хэрхэн холбогдож байна вэ? Энэ нь өөр нийгээс хэрхэн ялгагдаж байна вэ? Тухайн нийгмийн тасралтгүй буюу тогтвортой байдал хийгээд өөрчлөлтийн онцлог шинж нь юу вэ?
2. Тухайн нийгэм нь хүн төрөлхтөний түүхийн хаана нв зогсдог вэ? Түүний өөрчлөлтийн хөдөлгүүр нь юу вэ? Тухайн нийгэм хаана байрлаж байгаа вэ? Түүний нийт хүн төрөлхтний хүүнлэгийн хөгжилд ямар утга ач холбогдол бүхий вэ? Бидний шалган буй тодорхой шинж чанар нь хэрхэн нөлөө үзүүлдэг вэ? Түүхэн тодорхой нөхцөл байдалд хэрхэн нөлөө үзүүлдэг вэ? Тухайн түүхэн тодорхой үеийн онцлог шинж нь юу вэ? Энэ нь өөр үеүдээс ямар ялгаатай вэ? Тухайн нийгмийн түүхээ бүтээж буй гол онцлог, тодорхойлогч арга зам нь юу вэ?
3. Тухайн цаг үеийн хийгээд тухайн нийгэмд ямар ямар хэв маягийн эрэгтэй, эмэгтэйчүүд зонхилж байна вэ? Ямар хэв маягийн хүмүүс зонхилох хандлагатай болох вэ? Ямар арга замаар тэд сонгож, хэвшүүлж, дарангуйлж, чөлөөлж, мэдрэмжтэйгээр хийж, хүч нь суларч мохож байна вэ? Тухайн цаг үеийн тодорхой нийгмээс бидний хийж буй ажиглаглалтаар “хүний мөн чанар”-ын ямар шинжүүдийг илрүүлээд байгаа вэ? Бидний судлан буй нийгмийн шинж чанар бүрийн “хүний мөн чанар”-ын утга нь юу вэ?

Агуу том улс орон, хэл бичгийн цөөнх, гэр бүл, шорон, шашны сургаал зэрэг нв нийгмийн судалгааны шилдэг асуултууд юм. Эдгээр нь нийгмийн хүний талаарх сонгодог судалгааны оюун сэтгэлгээнийх нь тулгуур нь юм. Социологийн судлах асуултууд улам бүр өсөн нэмэгдэж байна. Социологи нь улс төрийн асуудлаас сэтгэл зүйн асуудлыг, нэг гэр бүлийг судлахаас дэлхийн улс орнуудын төсвүүдийг харьцуулан судлах, шашны сургуулийг судлахаас цэргийн байгууллагыг, газрын тосны үйлдвэрлэлээс орчин үеийн яруу найргийг судлах замаар нэг асуудлаас, хандлагаас нөгөөд шилжиж байна. Социологи нь хувийн биш, нийтийн гэхүйц асуудлаас хувь хүний хамгийн ойрын хүрээ хүртэлх бүхий л асуудлуудыг судлах чадавхитай. Тэр нь түүхэн тодорхой цаг үед тодорхой нийгэмд амьдарч буй хувь хүний нийгмийн болон түүхийн утга, ач холбогдлыг үргэлжид тодорхойлохыг шаардаж байдаг. Товчхондоо социологийн утга холбогдол нь юу гэвэл нийгэм дэх хувийн намтар хийгээд түүхэн үйл явцын огтлолцол дахь мөч бүрт ямар зүйлс өөрөө бий болж байна гэдгийг ойлгох, дэлхий ертөнцөд юу болж байгааг таньж мэдэх явдал юм. Орчин үеийн хувь хүн өөрийгөө гаднаас нь болон хөндлөнгийн хүн мэт харж ухамсарлах явдал нь түүх, нийгмийн харьцангуй байдлын хэрэгжилтэд уусан шингэдэг. Социологи нь энэхүү хувийн ухамсар сэтгэлгээний хамгийн үр ашигтай хэлбэр. Хүмүүсийн менталитет нь тэдний үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлагдсан багтаамжтай байдаг. Хүмүүс зөв ч, буруу ч өөрийн гэсэн дүгнэлт, үнэлгээ, цогц баримжаалалтай гэдгээ мэддэг. Өнөө үед хаа нэг сонсогдох хуучны гэхүйц шийдвэр нь хүмүүсийн хувьд ухаалаг бус, тооцоо муутай сэтгэж байсны үр дүн гэж тооцогддог. Тэдний чадавхи гайхалтай гэхүйц зүйлийг ахиад л бүтээж байдаг. Тэд сэтгэлгээний шинэ аргыг эзэмшиж, нийгмийн үнэт зүйлсийг дахин үнэлэн цэгнэж байдаг ба тэд өөрсдийн мэдрэмж, хариу үйлдлээрээ нийгмийн шинжлэх ухааны соёлын утга холбогдлыг бодит биелэл болгон хувиргадаг.

Хоёр.

Социологийн хувьд хувь хүний амьдралд тохиолдсон хүндрэл бэрхшээл хийгээд олон нийтийн өмнө тулгамдсан асуудал хоорондын ялгааг тодруулах нь чухал байдаг. Энэ нь социологийн судалгааны гол мөн чанар бөгөөд нийгмийн шинжлэх ухааны үндсэн шинж нь юм.

*Хүндрэл бэрхшээлүүд*² хувь хүний онцлог хүрээ хийгээд бусадтайгаа холбогдож буй холбоонд нь бий болдог. Хүмүүс өөрийн хувийн болон тухайн хувь хүн амьдарч, шууд харилцаж буй нийгмийн амьдралын хязгаарлагдмал хүрээнд үйлдлээ хийдэг. Хүндрэл бэрхшээлийг тухайн хувь хүний биологийн өгөгдөл, түүнийг хүрээлэн буй ойр дотно нийгмийн орчноос хамааруулан тодорхойлж, шийдвэрлэдэг. Нийгмийн сүлжээ нь хувь хүний туршлагыг нээхийн зэрэгцээ хийх үйлдэл үйл ажиллагааг нь өргөтгөж өгдөг. Хүндрэл бэрхшээл нь хувийн шинжтэй. Хувь хүмүүс үнэт зүйлсэд татагдаж, түүнийг цаашид ургуулан хөгжүүлдэг.

Асуудлууд нь хувь хүний дотоод тал болон түүнийг хүрээлэн буй бичил орчноос даван гарсан байдаг. Хувь хүн тухайн түүхэн нийгмийн институтуудын хүрээний, түүнийг хүрээлэн байгаа байгууллагатай хамтран ажиллах ёстой болдог. Ингэснээр өөрийн хүрээлэн буй бичил орчноос хальж нийгэм, түүхийн амьдралын томоохон хэсэг рүү нэвтрэн ордог. Асуудлууд нь олон нийтийн шинжтэй, олон нийт үнэт зүйсэд татагдаж, улмаар олон нийт түүнийг ургуулан хөгжүүлдэг. Үнэт зүйлс нь бодитойгоор оршдог эсэх, юу илүүтэй хүмүүсийг татаж байдаг тухай асуудлаар үргэлж маргалдаж байдаг. Энэхүү маргаан нь асуудлын мөн чанартай холбогддог тул анхаарлаа төвлөрүүлэн хандуулсан зүйл гэж байдаггүй. Учир нь асуудал хүмүүсийн хүрээнд нийтлэг байгаа хүндрэл бэрхшээл биш бөгөөд жирийн хүмүүсийн өдөр тутмын орчноор тодорхойлогддог зүйл биш аж. Ер нь асуудал бол нийгмийн институтын зохицуулалтад гарсан хямрал юм. Өөрөөр хэлбэл Марксистууд үүнийг зөрчил, мөн эсрэг тэсрэг байдал хэмээн нэрлэсэн билээ.

Энэ утгаар нь ажилгүйдлийг авч үзье. 100000 хүн амтай нэг хотод зөвхөн нэг хүн л ажилгүй. Энэ бол тухайн хувь хүнд тохиолдсон хүндрэл бэрхшээл. Мөн бид тухайн хувь хүний шинж чанарууд, түүний чадвар, түүнд байгаа боломжуудыг тодруулан харж чадна. Харин 50 сая ажил эрхэлж, 15 сая хүн ажилгүй байгаа нийгмийн тохиолдолд энэ бол асуудал. Хэрэв бид зөвхөн нэг л хүнд нээлттэй байгаа боломжоор нь хязгаарлан уг асуудлыг шийднэ гэвэл боломжгүй. Байгаа боломжууд уналтад орсон. Асуудлыг үнэн зөвөөр тодорхойлох хийгээд асуудлыг шийдэх боломжит шийдлийг олох явдал нь ажилгүй байгаа хувь хүмүүсийн нөхцөл байдал, тархай бутархай хувь хүмүүсийн шинжүүдэд биш харин тухайн нийгмийн улс төр, эдийн засгийн институтуудад анхаарлаа хандуулахыг биднээс шаарддаг.

Дайны асуудлыг авч үзье. Дайн гарлаа гэхэд хувь хүнд дараах асуудлууд гарч ирдэг. Яаж амьд үлдэх вэ? Яаж гавъяа байгуулах вэ? Яаж мөнгөтэй болж болох вэ? Цэргийн албаны илүү аюулгүй байр сууринд хэрхэн хүрэх вэ? Дайныг дуусгахад хувь нэрээ хэрхэн оруулах вэ гэх мэт. Товчоор хэлбэл хэн нэгний үнэт зүйлс, түүний хүрээлэн буй орчинтой нь холбогдуулан дайнаас амьд үлдэх хийгээд утга учиртайгаар үхэх тухай авч үзнэ. Харин дайны бүтцийн асуудал нь түүнд хүргэсэн шалтгаантай холбогдоно. Ямар хэв маягийн хүмүүс тушаал дагаж байна гэдэгт анхаарна. Улс төр, гэр бүл, шашны институтуудтэй холбон авч үзнэ. Үндэстний төр улсуудын ертөнцийн зохион байгуулалтгүй хариуцлагагүй байдалтай холбон авч үзнэ.

Гэрлэлтийг авч үзье. Гэрлэлт нь эрэгтэй, эмэгтэй хүнд хувийн хүндрэл бэрхшээлийг авчирж болзошгүй. Гэрлээд нэг жил болж буй хосуудын салалтын түвшинг авч үзвэл 1000 хосоос 250 нь салсан үзүүлэлт гарчээ. Энэ нь гэрлэлт, гэр бүлийн институт болон бусад институттэй холбон авч үзсэнээр бүтцийн асуудал болох юм.

Метропол хотууд буюу сайхан, муухай, гайхамшигт болон сэтгэл гутам зүйлээр дүүрэн том хотын асуудлыг авч үзье. Дээд ангийн хүн “Их хотын асуудал”-ыг хотын төвд байрласан машины зогсоол бүхий хувийн байртай байхын зэрэгцээ хотоос 40 милийн зайд Хенри Хиллийн хувийн хаус, 100 гаруй арк талбай бүхий хувийн эдлэн газар дээрээ Гаррет Эжбогийн цэцэрлэгтэй байхаар шийдвэрлэнэ. Эдгээр хүмүүс нь өөрийн хувийн онгоцоо ашиглах, цөөн тооны хүмүүсийг

² Зохиогч хүндрэл бэрхшээлийг (trouble) хувь хүнийх, асуудлыг (issue) олон нийтийнх хэзэн ялган авч үзсэн, энэ нь хэлний онцлогтой холбоотой болов уу.

ажиллуулах замаар хотын амьдралаас шалтгаалсан түүний орчинд гарч ирсэн хувийн асуудлуудаа шийдэж байдаг. Хотын бүтцэд холбогдох олон нийтийн асуудлуудыг хэдийгээр гайхалтай байгаа ч ийм аргуудаар шийдэж чаддаггүй. Тэгвэл нийтийн шинжтэй асуудлыг шийдэхийн төлөө юу хийх ёстой вэ? Хотыг амьдрангаа ажлаа хийх боломжтой жижиг тархай хэсгүүдэд хуваах уу? Хотыг сэргээн засварлах уу? Хотыг нүүлгэж шилжүүлсэний дараа шинэ газарт шинэ төлөвлөгөөгөөр шинэ хот байгуулах уу? Юуг төлөвлөсөн байх ёстой вэ? Хэн шийдэх, шийдсэнийг нь хэн бүтээн байгуулах вэ? Эдгээр нь бүтцийн асуудлууд юм. Хүмүүсийн бичил орчнуудад нөлөөлдөг улс төр, эдийн засгийн асуудалд анхаарлаа хандуулах замаар шийдэхийг биднээс шаарддаг.

Эдийн засагт хямрал гарч, ажилгүйдлийн асуудал нь хувь хүнээс хамааран шийдэгдэхгүй болдог. Дайн нь үндэстний төр улсуудад угаас байдаг, дэлхий дахины адил тэгш бус аж үйлдвэржилттэй холбоотойгоор гардаг зүйл. Дайны үед өөрийн хязгаарлагдмал орчиндоо жирийн хувь хүн сэтгэл заслын тусламжтай, тусламжгүйгээр түүнд олгогдсон боломж, боломжгүй байдлын алийгаар нь ч тулгарсан бэрхшээлээ шийдэх эрх мэдэлгүй болдог. Гэр бүлийн институтын хувьд эмэгтэйчүүд нь хонгор хөөрхөн үнэгүй хөдөлмөр эрхлэгч болж, эрэгтэйчүүд нь гэр бүлээ тэжээгч болон хувирдаг. Ингэснээр гэрлэлтэндээ сэтгэл хангалуун байх асуудал нь цэвэр хувийн шийдвэр гаргаад шийдэх асуудал биш болдог. Хэт хөгжсөн хотын хувьд хэт их ачаалал бүхий машин техник нь хэт хөгжсөн хотын шинжийг бүрдүүлж, хотод амьдрахтай холбоотой асуудал нь хувийн эд хөрөнгө баялаг болон мэргэн ухаанаар шийдэгдэх боломжгүй.

Олон янзын бөгөөд онцлог бүхий орчин дахь бидний амьдрал туршлага нь бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалж байдгийн миний бие тэмдэглэсэн. Хүмүүсийн хувийн орчинд гарч буй өөрчлөлтийг ойлгохын тулд бид тэднийг биш, тэдний цаана байгаа зүйлийг харах ёстой. Бүтцийн өөрчлөлтүүд нь нийгмийн институтуудыг нэмэгдүүлдэг. Тэрхүү институтуудын хүрээнд бид илүү хяналтан дор байх болж, өөр хоорондоо илүү төвөгтэй байдлаар холбогдож байна. Нийгмийн бүтцийн үзэл санааг ойлгох, түүнийг мэдрэмжтэйгээр ашиглахын тулд хувь хүмүүсийн орчнуудын хоорондын холбоог илрүүлэн дагах чадавхитай байх явдал. Мөн социологийн дүрслэлийг танин мэдэх боломжтой байх ...

Асуултууд:

- Социологийн дүрслэл гэж юу вэ? \Миллсийн өөрийнх нв хэлсэнийг шууд ишилж хэлж болох ба уг тодорхойлолтыг өөрийн үгээр тодорхойлох\
- Социологийн судалгаа хийх гэж хүн ямар төрлийн асуултуудыг өөртөө тавих вэ?
- Хувь хүний орчинд тулгарсан хүндрэл бэрхшээл гэж юу вэ? Жишээг хэлнэ үү. Нийгмийн бүтцийн олон нийтийн асуудал гэж юу вэ? Хувь хүний тулгарсан хүндрэл бэрхшээл хийгээл олон нийтийн асуудал хоорондын ялгаа нь социологид маш чухал гэж Миллс яагаад хэлсэн бэ?